



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/129

Батширээт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2, 18.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын хөрөнгөөр “Хушин-Эрдэнэ”ХХК-ийн Хурх багийн нутагт хийсэн татмын ойн тарилт, Норовлин багийн нутаг наадмын талбайн баруун энгэрийн ойд арчилгааны 1,2 дугаар зэргийн огтлолт явуулсан ажлыг хүлээн авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Төрмөнх – Засаг даргын орлогч

Гишүүд:

Г.Гантуяа – Сум Дундын ойн ангийн дарга

Б.Болд- Байгаль хамгаалагч

2. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, баримтжуулан актаар хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Төрмөнх)-д хариуцуулсугай.

3. Намрын улиралд амьдралтын түвшинг тогтоон үр дүнг тооцон ажиллахыг Сум Дундын ойн ангийн дарга (Г.Гантуяа)-д үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА

БАЛТАНГЭРЭЛ

234504253